



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/368

Мандалговь

Газар зүйн нэрийн салбар зөвлөл
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.1, 5.8.2, 5.8.4, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 186 дугаар зарлиг, УИХ-ын 2003 оны 42 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн "Газар зүйн нэрийн салбар зөвлөл"-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Салбар зөвлөлийн дарга:
Гишүүд:

Аймгийн Засаг даргын орлогч
Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын нарийн бичгийн дарга
Цэргийн штабын дарга
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн дарга
Боловсрол, соёл, урлагын газрын
дарга
ЗДТГ-ын Архивийн тасгийн дарга
Санхүү, төрийн сангийн хэлтсийн
дарга
Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын дарга
"Их газрын чулуу" Тусгай
хамгаалалттай газрын дарга
Цагдаагийн газрын дарга
Зэвсэгт хүчний дугаар ангийн
захирагч
"Мэдээлэл, холбоо сүлжээ" ТӨХК-ийн
Дундговь салбарын дарга
"Монголын цахилгаан холбоо" ХК-ийн
Дундговь салбарын дарга
Авто тээврийн төвийн дарга
Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын геодези, зураг
зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн

488191036

Нарийн бичгийн дарга:

Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын дарга

2. "Газар зүйн нэрийн салбар зөвлөл" байгуулахтай холбогдуулан 15 суманд зөвлөл байгуулах тухай заавар, зөвлөмжийг хүргүүлж, хийгдэх ажлын төлөвлөгөө боловсруулан мөрдөж ажиллахыг (Салбар зөвлөлийн дарга)-д даалгасугай.

3. "Газар зүйн нэрийн хээрийн тодруулалтыг аймгийн хэмжээнд хийх" ажлыг зохион байгуулах, "Газар зүйн нэрийн мэдээллийн сан" бүрдүүлэх, шинээр өгөх, өөрчлөх газар зүйн нэрийн саналыг хэлэлцэн Газар зүйн нэрийн зөвлөлд хүргүүлэх болон бусад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тухай бүрд шийдвэрлэн ажиллахыг (Санхүү, төрийн сангийн хэлтэс), (Нарийн бичгийн дарга) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ